


Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 31 ний өдрийн А/08 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



**Нэг: Зорилго:**

Монгол улсад коронавирусын халдвар /Covid-19/ бүртгэгдэж, улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан албан хаагчид болон үйлчлүүлж буй иргэдийг халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдолд шуурхай арга хэмжээ авахад оршино.

**Хоёр: Хэрэгжүүлэх хугацаа:**

“Ажлын тусгай горимд шилжих үеийн удирдамж”-ийг 2020 оны 04-р сарын 01 ны өдрөөс 04-р сарын 30 ны өдөр хүртээ дагаж мөрдөнө.

**Гурав: Хамрах хүрээ:**

ЗДТГ-ын нийт албан хаагчид

**Дөрөв: Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байгууллагын 0-12 насны хүүхэдтэй ээж, жирэмсэн албан хаагчдыг гэрээсээ ажиллах боломжоор хангаж, байгууллагын өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажиллаж болно. Энэ тохиолдолд дараах зарчим баримтлана.

1. Яаралтай үед холбоо барих боломжтой байх буюу гар утсаа унтраахгүй байх, удирдлагаас дуудсан үед хүрэлцэн ирэх
2. Хөдөө болон хот, аймаг руу олон хоногоор зорчихгүй байх
3. Удирдлагын цохолттой хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэхэд анхаарч ажиллах
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаар, биелэлтийг тооцож ажиллах
5. Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажлын хэсэгт томилогдон ажиллаж байгаа албан хаагчид хүлээсэн үүргээ хангаж ажиллах